# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
# ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот

┌ "Монгол газар гоулд" хоршооны хадгаламж, ┐
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Монгол газар гоулд" хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2009 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгалтын талаарх тэмдэглэгээг 2010 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлж хийлгэхийг Хоршооны дарга Б.Чинбатад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН